

Солонгост оршин сууж буй гадаад хүүхдүүдэд(5~11 нас)  
COVID-19-ийн эсрэг вакцинжуулалтанд хамруулах тухай мэдээлэл

Омикрон хувилбарын тархалтаас үүдэлтэйгээр өвчлөл эрс нэмэгдэж, өмнө нь вакцинжуулалтад хамруулах бүлэгт ордоггүй байсан 5~11 насны хүүхдүүдийн дунд халдварын тохиолдлын тоо огцом өсч байгаа ба хүнд хэлбэрийн өвчлөл болон нас баралт ч мөн тохиолдож байна. Үүний улмаас 5~11 насны хүүхдүүдийг COVID-19-ийн эсрэг вакцинд хамруулах талаар дараах мэдээллийг хүргэж байгаа болно.

■ Вакцинжуулалтад хамрагдах хүн

○ 5~1 насныханд хамаарах ба, суурь өвчтэй өвчин хүндрэх өндөр эрсдэл бүхий хүүхдүүд вакцинд хамрагдсанаар COVID-19-ийн хүнд хэлбэрийн халдвараас урьдчилан сэргийлэх боломжтой тул вакцинд зайлшгүй хамрагдахыг зөвлөж байна.

○ Эрүүл хүүхдүүдийн хувьд вакцинжуулалтын ашиг тус, COVID-19-ийн халдвар, вакцин хийлгэсний дараах сөрөг хариу урвалын эрсдэлийг сайтар судалсны дараа сайн дурын үндсэн дээр вакцинд хамрагдахыг зөвлөж байна.

※ Хэрэв халдвар авч байсан бол вакцин хийлгэхийг зөвлөхгүй, мөн 1-р тун хийлгэсний дараа халдвар авсан тохиолдолд 2р тунг хийлгэхийг зөвлөхгүй болно.

■ Вакцины төрөл ба тун хоорондын зай

○ Pfizer хүүхдийн вакцин (насанд хүрэгчдийн вакцины идэвхтэй бодисын 1/3-ийг агуулсан найрлагатай)

○ Хүүхдүүдийн хувьд эхний тунгаа хийлгэснээс хойш 8 долоо хоногийн(56 хоног) дараа 2дахь тунгаа хийлгэж болно.

\* Хэрэв эрүүл мэндийн шалтгаан эсвэл хувийн нөхцөл байдлын улмаас хоёр дахь тунг эрт хийх шаардлагатай бол Хүнс, эмийн аюулгүй байдлын яамнаас зөвшөөрөгдсөн тун хоорондын хугацаа болох 3 долоо хоногийн (21 хоног) дотор хийлгэж болно.

■ Урьдчилсан захиалга өгөх арга

▷ Урьдчилсан захиалгыг 2022 оны 3-р сарын 24-ний(Пүрэв гараг) өдрөөс эхлэн хийх боломжтой.

1. Бүртгэлтэй гадаадын иргэн

① Онлайн захиалга: COVID-19 вакцинжуулалтын урьдчилсан захиалгын системд (<https://ncvr.kdca.go.kr>) нэвтрэн асран хамгаалагч төлөөлөн захиалга

② Утсаар захиалга өгөх: Өвчнийг хянах, урьдчилан сэргийлэх газрын дуудлагын төв (☎1339) эсвэл орон нутгийн засаг захиргааны дуудлагын төвд асран хамгаалагч хүүхдийг төлөөлөн захиалга өгөх

③ Тухайн өдөр хийлгэх вакцин: Эмнэлгийн байгууллагуудын урьдчилсан жагсаалтад(утсаар баталгаажуулах) бүртгүүлсний дараа тухайн өдөр вакцинд хамрагдах

Бүртгэлгүй гадаадын иргэд(хууль бусаар оршин суугаа иргэд): Вакцинжуулалт хийлгэхдээ эрүүл мэндийн газраас авсан түр хяналтын дугаараа ашиглан утсаар болон тарилга хийгдэж байгаа газар(эмнэлэг, эрүүл мэндийн төв) биечлэн очиж захиалга өгөх.

\*Түр хяналтын дугаар олгох үед гадаад паспорт, гадаадын иргэний үнэмлэх зэрэг биеийн байцаалтыг шаардахгүй болно.

■ Вакцин хийх газар болон хугацаа

▷ Вакцинжуулалт 2022 оны 3-р сарын 31-ээс (Пүрэв гараг) хүчин төгөлдөр болно.

○ Хүүхдийн вакцинжуулалт хийгдэх 1200 орчим эмнэлгийн байгууллага байгаа бөгөөд 3-р сарын 14-өөс (Даваа гарагт) Корона 19 вакцинжуулалтын вэбсайтаас ([ncv.kdca.go.kr](http://ncv.kdca.go.kr)) шалгах боломжтой.

※ <Мэдэгдэл· Маягт> → <Удирдамж> цэсээс хэрэгжилтийн стандарт, заавар, сургалтын материал, итгэмжлэгдсэн эмнэлгийн байгууллагуудыг шалгаж болно.

Хүүхдүүдийн хувьд тарилгын аюулгүй байдал, гаж нөлөө зэргийг хянах шаардлагатай улмаас асран хамгаалагч, хууль ёсны төлөөлөгч нь зайлшгүй хамт байлцах шаардлагатай. (Асран хамгаалагч хүүхэдтэйгээ хамт ирж, биеийн байцаалтаа баталгаажуулсны дараа урьдчилан оношлох хуудсыг бөглөх)

※ Жич

- Хувь хүний мэдээллийг зөвхөн вакцинжуулалтын зорилгоор ашиглах бөгөөд мэдээлэх үүргээс чөлөөлөх журмын дагуу Цагаачлалын албанд хууль бусаар оршин суугч болохыг мэдээлэхгүй болно.

- Бусад тодорхой мэдээллийг Халдварт өвчин хянах урьдчилан сэргийлэх газар Корона19 вакцинжуулалт Нүричиб (<https://ncv.kdca.go.kr>)-с шалгана уу.